

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан  
Утас: 99008827

Цахим хаяг: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1. Залруулсан алдаа.....	14
4.2. Албан шаардлага.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
6. Аудитын тайлангийн хавсралт .....	16
6.1. Албан шаардлага №110 /А2370452/ ХЭА-2022/39/НА-СТА-ТШЗ.....	16
6.2. Албан шаардлага №111 /А2370452/ ХЭА-2022/39/НА-СТА-ТШЗ.....	17
6.3. Албан шаардлага №112 /А2370452/ ХЭА-2022/39/НА-СТА-ТШЗ.....	18
6.4. Албан шаардлага №113 /А2370452/ ХЭА-2022/39/НА-СТА-ТШЗ.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.09 № 176

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030082

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>46,178,368.2</b>	<b>118,929,017.0</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	103,124.90	806,791.40
33200	Төлбөргүй үйлчилгээний авлага	10,783.50	714,450.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		
34600	Урьдчилж гарсан зардал	92,341.40	-92,341.40
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		
35130	Эм боох материал	-	355,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		
35410	Бичиг хэргийн материал	45,661,043.33	65,093,875.33
35420	Аж ахуйн материал	658,800.00	614,000.00
35440	Түлш, шатах тослох материал	22,208,167.99	38,246,557.99
35460	Хүнсний материал	1,638,324.00	2,563,400.00
35470	Бусад хангамжийн материал	171,034.00	400,000.00
		20,984,717.34	23,269,917.34
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>912,431,906.87</b>	<b>885,644,863.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		
39201	Барилга, байгууламж, орон сууц	912,431,906.87	885,644,863.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	777,551,906.87	750,764,863.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	667,835,906.80	671,335,906.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,771,808.73)	(49,026,624.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,500,000.00	18,500,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,927,777.81)	(10,011,111.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,127,203.91	146,175,860.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(56,193,646.46)	(81,141,684.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,289,913.35	60,841,913.35
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31,134,245.38)	(37,344,619.87)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		
39301	Програм хангамж	48,684,355.00	48,684,355.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(11,857,993.81)	(17,249,131.45)
39303	Бусад биет бус хөрөнгө	134,880,000.00	134,880,000.00
		450,000.00	450,000.00
		(450,000.00)	(450,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>958,610,275.10</b>	<b>1,004,573,880.32</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>958,610,275.10</b>	<b>1,004,573,880.32</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	958,610,275.10	1,004,573,880.32
51101	Өмч: - төрийн	173,589,407.88	173,589,407.88
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	173,589,407.88	173,589,407.88
51220	Тайланг үеийн үр дүн	523,599,299.67	569,562,904.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	523,599,299.67	523,599,299.67
		-	45,963,605.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>261,421,567.55</b>	<b>261,421,567.55</b>
		<b>958,610,275.10</b>	<b>1,004,573,880.32</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайланг хугацаа 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	465,713,166.00	532,731,525.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,766,505.00	28,676,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,766,505.00	28,676,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,766,505.00	28,676,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,766,505.00	28,669,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	417,946,661.00	504,055,325.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	314,779,700.00	294,304,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	314,779,700.00	294,304,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,336,161.00	156,525,025.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнэгэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	36,920,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,128,000.00	109,845,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	3,208,161.00	9,758,625.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,830,800.00	53,225,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,830,800.00	53,225,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	432,383,102.99	486,757,919.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	432,383,102.99	486,757,919.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401,263,916.47	455,440,176.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,388,019.73	170,550,151.40
210101	Үндсэн цалин	94,510,936.32	114,673,399.92
210102	Нэмэгдэл	13,145,530.99	15,719,381.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,731,552.42	4,200,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	35,957,370.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,578,514.25	23,631,006.07
210201	Тэтгэврийн даатгал	8,466,579.79	17,111,711.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,009,157.51	1,629,825.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	806,966.56	1,303,859.98
210204	Ажигүйдлийн даатгал	331,994.15	325,964.95
210205	Эрүүд мэндийн даатгал	1,963,816.24	3,259,644.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,952,955.00	48,817,283.89
210301	Гэрэл, цахилгаан	8,092,415.00	8,736,183.89
210302	Түлш, халаалт	29,354,500.00	35,459,954.00
210303	Цэвэр, бохир ус	1,477,586.00	1,793,146.00
210304	Байрны түрээс	2,028,454.00	2,828,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,514,088.40	18,387,311.05
210401	Бичиг хэрэг	9,343,620.00	6,690,590.00
210402	Тээвэр, шатахуун	9,206,891.00	4,886,874.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	1,253,683.00	3,191,886.05
210404	Ном, хэвлэл	-	652,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,059,094.40	954,000.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,650,800.00	2,011,961.00
2105	Нормативт зардал	912,950.00	7,051,763.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,123,560.00
210502	Хоол, хувьс	-	3,538,203.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	912,950.00	390,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,359,150.00	13,046,830.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	1,523,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	315,280.00
210604	Урсгал засвар	7,359,150.00	11,208,450.00
2107	Томилголт, зочны зардал	2,096,000.00	4,099,500.00
210702	Дотоод албан томилголт	2,096,000.00	4,099,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,264,026.50	72,368,837.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,902,073.50	62,100,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	4,245,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	48,064.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,507,038.10
210807	Газрын төлбөр	37,953.00	37,935.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,198,212.59	97,487,493.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,166,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,869,344.50	28,775,130.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	52,328,868.09	60,546,143.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,119,186.52	31,317,743.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,718,700.00	25,384,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,718,700.00	25,384,350.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	307,981.00	965,943.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	221,745.00	26,630.11
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх	86,236.00	939,313.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,092,505.52	4,967,449.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,092,505.52	4,967,449.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,330,063.01	45,973,605.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,999.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	9,999.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(9,999.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,330,063.01	45,963,605.22

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,589,407.88	261,421,567.55	493,078,014.60		928,088,990.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,808,777.94)	2317144297	(2,808,777.94)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,589,407.88	261,421,567.55	490,269,236.66	61740048	925,280,212.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	33,330,063.01	-	33,330,063.01
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,589,407.88	261,421,567.55	523,599,299.67	-	958,610,275.10
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	173,589,407.88	261,421,567.55	523,599,299.67	-	958,610,275.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,589,407.88	261,421,567.55	523,599,299.67	-	958,610,275.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	45,963,605.22	-	45,963,605.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,589,407.88	261,421,567.55	569,562,904.89	-	1,004,573,880.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>417,946,661.00</b>	<b>504,062,325.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	7,000.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	7,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>417,946,661.00</b>	<b>504,055,325.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>314,779,700.00</b>	<b>294,304,900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	314,779,700.00	294,304,900.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>47,336,61.00</b>	<b>156,525,025.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	36,920,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,128,000.00	109,845,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,208,61.00	9,758,625.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>55,830,800.00</b>	<b>53,225,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,830,800.00	53,225,400.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>417,946,661.00</b>	<b>498,962,425.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>417,946,661.00</b>	<b>498,962,425.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>384,263,074.48</b>	<b>467,578,431.31</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>101,717,943.96</b>	<b>170,892,698.40</b>
210101	Үндсэн цалин	84,840,860.55	108,157,412.05
210102	Нэмэгдэл	13,145,330.99	17,321,430.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,731,352.42	4,456,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	40,957,856.35
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,927,151.02</b>	<b>22,189,478.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,738,365.79	16,221,797.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,047,482.51	1,491,921.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	837,629.14	1,193,537.46
210204	Ажилгүйдлийн даатгал	209,406.34	298,384.41
210205	Эрүүл мэндийн даатгал	2,094,067.24	2,983,837.46
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,322,955.00</b>	<b>50,549,329.89</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,092,415.00	8,736,183.89
210302	Түлш, халаалт	34,724,300.00	37,192,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,477,586.00	1,793,146.00
210304	Байрны түрээс	2,028,454.00	2,828,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,991,148.00</b>	<b>19,653,687.05</b>
210401	Бичиг хэрэг	10,716,500.00	4,449,090.00
210402	Тээвэр, шатахуун	10,408,365.00	3,953,400.00
210403	Шуудан, холбоо, инфернэгийн төлбөр	1,253,583.00	3,191,886.05
210404	Ном, хэвлэл	672,000.00	625,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	740,000.00	954,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,500.00	6,480,311.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>1,661,000.00</b>	<b>6,736,860.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,459,130.00
210502	Хоол, хүнс	-	4,742,880.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдгэл	1,661,000.00	534,850.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>42,445,663.00</b>	<b>71,171,180.30</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,709,588.00	28,694,000.00
210602	Тавилга	9,990,325.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	690,280.00
210604	Урсгал засвар	26,745,150.00	41,786,900.30
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>2,096,000.00</b>	<b>4,099,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,096,000.00	4,099,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>81,117,945.00</b>	<b>79,685,697.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,755,392.00	69,417,660.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,300.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	4,245,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	-	48,064.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,507,038.10
210807	Газрын төлбөр	37,353.00	37,353.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>68,983,268.50</b>	<b>42,600,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,146,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,983,268.50	34,453,150.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,683,586.52</b>	<b>31,383,993.69</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,283,100.00</b>	<b>25,450,600.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,208,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,074,400.00	25,450,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийтөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	307,981.00	965,943.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	221,745.00	26,630.11
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	86,236.00	939,313.62
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,092,505.52</b>	<b>4,967,449.96</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,092,505.52	4,967,449.96
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	<b>5,099,900.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>5,099,900.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>5,099,900.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>5,099,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,099,900.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>(5,099,900.00)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>347,530,300.00</b>	<b>342,543,219.93</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>347,530,300.00</b>	<b>342,543,219.93</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>324,817,100.00</b>	<b>320,092,619.93</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>153,946,600.00</b>	<b>152,322,284.40</b>
210101	Үндсэн цалин	89,930,400.00	89,650,702.05
210102	Нэмэгдэл	17,745,700.00	17,321,430.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,324,000.00	4,456,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,946,500.00	40,894,152.35
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,409,100.00</b>	<b>21,146,162.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,377,300.00	15,178,481.29
210202	Тэтгэмжийн даатгал	1,757,300.00	1,491,921.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,406,300.00	1,193,537.46
210204	Ажилгүйдлийн даатгал	351,500.00	298,384.41
210205	Эрүүл мэндийн даатгал	3,515,500.00	2,983,837.46
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,831,900.00</b>	<b>48,812,269.89</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,200,300.00	8,439,123.89
210302	Түлш, халаалт	34,451,300.00	37,192,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,300.00	1,793,146.00
210304	Байрны түрээс	1,680,300.00	1,388,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,140,400.00</b>	<b>15,341,626.05</b>
210401	Бичиг хэрэг	3,000,300.00	2,979,090.00
210402	Тээвэр, шатахуун	4,056,400.00	3,590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,420,300.00	3,191,886.05
210404	Ном, хэвлэл	700,300.00	625,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	664,300.00	664,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,300,300.00	4,291,650.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>481,000.00</b>	<b>405,000.00</b>
210502	Хоол, хүнс	481,000.00	405,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,388,200.00</b>	<b>7,377,680.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,294,700.00	2,293,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	700,300.00	690,280.00
210604	Урсгал засвар	4,393,500.00	4,393,500.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>3,840,900.00</b>	<b>3,763,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,840,900.00	3,763,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,526,200.00</b>	<b>45,808,097.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийслэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,543,500.00	35,540,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,250,000.00	4,245,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	48,064.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,710,700.00	5,507,038.10
210807	Газрын төлбөр	420,000.00	37,935.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,252,800.00</b>	<b>25,116,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,416,500.00	6,321,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,836,300.00	18,794,150.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,713,200.00</b>	<b>22,450,600.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,713,200.00</b>	<b>22,450,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,713,200.00	22,450,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>347,530,300.00</b>	<b>342,543,219.93</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>294,304,900.00</b>	<b>289,330,450.04</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлээс санхүүжих	294,304,900.00	289,330,450.04
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>53,225,400.00</b>	<b>53,205,769.89</b>
132001	Орон нутгийн төсвөөс	53,225,400.00	53,205,769.89
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	7,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр / Гүйцэтгэл
I	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>156,525,025.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>156,525,025.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>152,585,711.38</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>18,570,414.00</b>
210101	Үндсэн цалин	18,506,710.00
210105	Гэрээт ажлын хөлс	63,704.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,043,316.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,043,316.08
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,737,060.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	297,060.00
210304	Байрны түрээс	1,440,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,312,061.00</b>
210401	Бичиг хэрэг	1,470,000.00
210402	Тээвэр, шатахуун	363,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	290,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,188,661.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>6,331,860.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,459,130.00
210502	Хоол, хүнс	4,337,880.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	534,850.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>68,893,400.30</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,000,000.00
210604	Урсгал засвар	40,893,400.30
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>336,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	336,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,877,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,877,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,484,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,825,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,659,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,939,313.62</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>939,313.62</b>
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	939,313.62
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>156,525,025.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>156,525,025.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,920,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,845,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,758,625.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын эрхэм зорилго нь “Тогтвортой, аз жаргалтай, ирээдүйд итгэлтэй гэр бүл, хүүхэд, залуучуудыг төлөвшүүлэх, хөгжүүлэх тэдний эрхийг хамгаалахад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 432.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	0.1	0.8	0.7
Урьдчилгаа	0.4	52.7	52.3
Бараа материал	45.7	65.4	19.8
Үндсэн хөрөнгө	912.4	885.6	(26.8)
Нөөцийн бараа	-	-	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>958.6</b>	<b>1,004.6</b>	<b>46.0</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	958.6	1,004.6	46.0
Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/	173.6	173.6	-
Өмнөх үеийн үр дүн	523.6	523.6	-
Тайлант үеийн үр дүн	-	46.0	46.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261.4	261.4	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>958.6</b>	<b>1,004.6</b>	<b>46.0</b>

Авлага дансны үлдэгдэлд татварын байгууллагаас авах 0.8 сая төгрөгийн авлага байна.

Урьдчилгаа дансанд Залуучуудын хөгжлийн төвийг шинэчлэн засварлаж жишиг төв байгуулах ажлын урьдчилгааг бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65.4 сая болж 19.8 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 5.1 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 28.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил данснаас акталсан 1.4 сая, тооллогоор дутагдаж зарлагадсан 0.3 сая төгрөгөөр хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,004.6 сая болж 46.0 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 67.0 сая төгрөгөөр буюу 14.4 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 54.4 сая төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал байр ашиглалттай холбоотой тогтмол зардал байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 455.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 108.3 сая төгрөгөөр бууруулж 347.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэх 347.5 сая төгрөгийн төсөв баталсныг тусгай зориулалтын шилжүүлгээс 294.3 сая, орон нутгийн төсвөөс 53.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 294.3 сая, нутгийн төсвөөс 53.1 сая нийт 347.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 342.5 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 5.0 сая, орон нутгийн төсөвт 0.03 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 36.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 109.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон

нэмэлт орлого 9.8 сая, нийт 156.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 155.6 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 0.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хэнтий аймгийн Гэр бүл, залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд хамгаалал болон нийгмийн бүлэгт чиглэсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан сургалтын зардлын 35.6 хувийг хоол, цайны зардалд зарцуулж байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 655.7 сая төгрөгийн 39 гүйлгээнээс 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 5.3 сая төгрөгийн 1, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 261.6 сая төгрөгийн 16, зарлагын 58.0 сая төгрөгийн 3 гүйлгээ нийт 324.9 сая төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон 2.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 29.8 сая төгрөгийн 4 албан шаардлага, 441.3 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна. Актын төлбөрийг бүрэн барагдуулж, 4 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогын зарцуулалтад анхаарал хандуулан авч үзэх болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 339.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 337.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.1. Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тооллогоор дутагдаж акт тавигдсан 1.3 сая төгрөгийн вакум хаалтыг бараа материал данснаас хасаж залруулав.
2. Тооллогоор дутагдаж акт тавигдсан 0.2 сая төгрөгийн гантелыг үндсэн хөрөнгө данснаас хасаж залруулав.

#### 4.2. Албан шаардлага

Аудитаар 12.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Орон сууцанд амьдарч байгаа албан хаагчдад түлээ нүүрсний хэнгөлөлтөд 0.9 сая төгрөгийг олгосон.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 10.2 сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 1.5 сая төгрөгийн цалингийн зардал шилжүүлж эдийн ангилал зөрүүлэн гүйлгээ хийсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ГБХЗХГ	4	14.1	2	1.5			3	12.6		
Дүн		4	14.1	2	1.5			3	12.6		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ГБХЗХГ	1	324.9					1	324.9		
Дүн		1	324.9					1	324.9		
Нийт дүн		5	339.0	2	1.5			4	337.5		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 110 / А 2370452  
ХЭА 2022 / 39 / НА - СТА ТЦС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Монгол Улсын газрын тогтоолоор орон сууцанд амьдарч байгаа өрхийн халаалтын төлбөрийг төрөөс бүрэн хариуцан төлсөн байхад орон сууцанд амьдарч байгаа албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 900.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Энх-эрдэнэ, нягтлан бодогч Д.Ганзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 111/А2370452  
ХЭА 2022/39/НА ЕТА-ТЛС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны сайтад мэдээлбэл зохих 324.9 сая төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Энх-Эрдэнэ, нягтлан бодогч Д.Ганзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер

Б.Хуланхатан

Д.Оюунтуяа



023040484



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 112/А2370452  
ХЭА 2022/39/НА-СТА ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 10.2 сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Энх-Эрдэнэ, нягтлан бодогч Д.Ганзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер

Б.Хуланхатан

Д.Оюунтуяа





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 113/АД370452  
ХЭА-2022/39/НА-СА-7143

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас 1,477.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал шилжүүлж эдийн ангилал зөрүүлэн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүлж гүйлгээ хийдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Энх-Эрдэнэ, нягтлан бодогч Д.Ганзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер

Б.Хуланхатан

Д.Оюунтуяа

2317144297

СЮА0046 9074082